

Паул Грамын дэвшүүлсний дагуух бизнес эрхлэгчдийн 12 бүтэлгүйдлийн шалтгаан.

Паул Грам гэж хэн бэ?

Тэрээр зохиолч бөгөөд Код болон эсэ бичдэг нэгэн. 2005 онд Паул Грам 3 найзтайгаа хамтран "YCombinator"-ийг үүсгэн байгуулсан.



### 1. Гоцлон тоглогч байх

Компани ажиллуулах нь зугаалахтай адил зүйл биш. Чамайг дэмжих юмуу бурууг чинь заах хүнгүйгээр эрт орой хэзээ нэгэн цагт алдаа гаргаж урагшлахад хүндрэлтэй болно.



### 2. Бичил зах зээл онилох

Маш олон бизнес эрхлэгчид өрсөлдөөнөөс зайлсхийхийн тулд жижиг зах зээлийг сонгодог. Энэ нь мэдээж оновчтой биш. Тиймээс томоор сэтгэж өрсөлдөгчдийг сайн талаас нь харах нь өөрөө том боломжинд ойртуулна.



### 3. Бусдыг дуурайх

Ихэнх YCombinator-ийг зоригсдын бизнес санаа хуулбар байдаг. Харин бизнес эхлүүлэх хамгийн зөв эх сурвалж бол асуудлыг шийдэх гаргалгаа.



### 4. Хэрэглэгчидтэйгээ харилцахгүй байх

Хамгийн шилдэг бөгөөд найдвартай асуудлыг таних арга бол түүнтэй шууд харьцаж буй хүмүүстэй ярилцах. Хэдий шууд шийдвэрлэж болохоор байсан ч гадны мэдээлэл ашигтай байж болно.



### 5. Уян хатан бус байдал

Гарааны бизнес бол яг л шинжлэх ухаан шиг. Түүнийг хаашаа ч чиглэсэн дагаж явах хэрэгтэй. Гэхдээ энэ нь өдөр бүр санаагаа өөрчилж болно гэсэн үг биш харин бодолтойгоор өмнөх хувилбараа илүү дээрээр солих хэрэгтэй



### 6. Маш удаанаар эхлэх

Ямар ч төрлийн бизнес эхлүүлэхэд төгс байлгахыг хүсэх эсвэл алдаанаас айх айдас зэргээс үүдэн үйл ажиллагаагаа эхлэхгүй байх нь цаг мөнгөний нөөцөө үрч сэтгэл зүйгээрээ хохирохын нэмэр. Бэлэн болсон гэж үзсэнээсээ өмнө эхлэх нь зөв.



### 7. Санхүүгийн нөөцгүй байх

Өөрийн төсөлдөө тааруулан хангалттай хэмжээний санхүү төсөвлөх хэрэгтэй бөгөөд Паул Грам бизнесийн эхний шатандаа аль болох боломжтойгоор нь зардлаа хэмнэхийг зөвлөсөн байдаг.



### 8. Орлого биш баялгийг анхаар

Харилцагч, үйлчлүүлэгчдийхээ үнэ цэнийг өсгөх тусам баялаг ихэснэ. Тэр чинээгээрээ компанийн үнэ цэнэ өснө. Баялгийг бий болгоход мөнгө түүнийг дагдаг гэдгийг Паул Грам зөвлөжээ.



### 9. Хувиараа сурталчлахаас ичих

Хэдий энэ нь тохиромжтой бус ч гэлээ бусдад мэдээллэхгүй л бол хэн ч мэдэхгүй. Хүн бүрлүү утас цохиж, сошл дээр постлох, и-мэйл бичих нь тийм ч таатай зүйл биш ч гэлээ хэрвээ энэ бүгдийг хийж чадвал амжилт авчирна.




### 10. Хөрөнгө оруулагчдын эрхэнд орох

Зарим хөрөнгө оруулагчид компанийн тухай мэдлэг бага ч гэсэн шийдвэрт оролцохыг завддаг. Тэр үед үгэнд нь авталгүй зүгээр л сонсоод өнгөрөх аль эсвэл хамтрагчтайгаа зөвлөлдөх нь зүйтэй.



### 11. Хортой харилцаа

Ихэнх гарааны бизнес хамтрагчийн үл ойлголцол юмуу тайван замаар маргалддаггүйгээс алддаг. Бизнес эхлүүлэх нь гэр бүл зохиохтой адил бөгөөд хамгийн ихээр итгэдэг зовлонгоо хуваалцаж болох хүнтэй хамтрах хэрэгтэй.



### 12. Бүхнээ дайчлахгүй байх

Зарим гарааны бизнес эрхлэгчид зөвхөн гол ажилдаа төвлөрөхгүйгээр давхар ажлаараа стартап-ыг сонгодог. Ингэснээр сүүлдээ эцэж үналтад орох болно. Паул Грам-ын хэлснээр бүхнээ дайчлахгүй байх нь хамгийн том алдаа.